



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/Ам

Дадал сум

┌ Орон нутгийн хөгжлийн сангаас зардал ┐
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3, 4 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх "Мал тарилгын хашааг"Баян-Овоо багийн Балжийн адагт, "Агац багийн Баянголд" шинээр барих, Агац багийн Читийн тасагт малын хашааг засварлах ажлуудын санхүүжилтийн урьдчилгаа 5,000,000 (Таван сая) төгрөгийн зардал гаргасугай.

2.ХЭАДСЗДТГ/20250301006,ХЭАДСЗДТГ/20250301005-03 дугаартай гэрээний дагуу 5,000,000 (Таван сая) "Эв нэгдэл" нөхөрлөлийн ахлагч Ч.Ариунболдын ХААН банкны 5944048148 тоот дансанд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн данснаас шилжүүлэхийг Сангийн нягтлан бодогч (Э.Өлзийсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

012000342